



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2022 ОН)

ХОВД ХОТ

ХОВД АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2022 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2022.12.30

Ховд

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Монгол улсын Засгийн газрын 2014 оны 327-р тогтоол, Аймгийн Засаг даргын 2014 оны 11-р сарын 10-ны өдрийн А/577 тоот захирамжаар байгуулагдаж, 2022 онд албаны дарга-1, ахлах байцаагч-3, байцаагч-3, дотоод аудитор-3 дотоод ажилтан-1 нийт 11 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны зорилго нь: Монгол улсын хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны зарчим: Албаны үйл ажиллагаа нь ил тод, биеэ даасан, хараат бус байж, хяналт шалгалтын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтлана.

Үйл ажиллагааны чиглэл: Орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийнэ.

Дээрх зорилгоос 2022 онд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллалаа.

1. Хяналт шалгалтын үр өгөөжийг дээшлүүлж, санхүүгийн ажилтнуудын сахилга батыг сайжруулах.

2. Албаны дотоод үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, боловсон хүчний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх.

Ховд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргаар Г.Өөдэй, санхүүгийн Улсын ахлах байцаагчаар Ц.Бадрал, Ж.Цэнд-Аюуш, Д.Болормаа нар, Санхүүгийн хяналтын улсын байцаагчаар П.Мягмартүвшин, У.Гандэмбэрэл, Н.Балт нар, дотоод аудитораар Т.Аззаяа, Г.Ариунчимэг, Э.Сүхтулга нар, дотоод ажилтнаар Д.Пүрэвдулам, нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд албаны хурлыг 2 удаа хийж, хяналт шалгалтаар илэрч буй зөрчил дутагдлыг арилгах, графикт шалгалтыг төлөвлөсөн цаг хугацаанд нь явуулж байгууллагын даргатай байгуулсан төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг ханган биелүүлэх, цаг үеийн асуудлуудыг тухай бүр

авч хэлэлцсэн.

Аймгийн Засаг даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөгөөр хөдөөгийн 8 сумын 71 төсөвт байгууллага, тусгай сангууд, Жаргалант сумын ЗДТГ, ИТХ, тусгай сангууд, аймгийн төвийн 18 байгууллага, нийт 89 байгууллага, тусгай сангуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр төлөвлөж, батлагдсанаас 12 дугаар сарын байдлаар төлөвлөгөө бүрэн хэрэгжиж, өргөдөл, гомдлын дагуу аймгийн төвийн 7 байгууллагад хяналт шалгалтын ажлууд хийгдэж дуусаад байна.Үүнд:

Жаргалант сумын 14-р цэцэрлэг, Шим-ус ОНӨААТҮГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мянган угалзат орон нутгийн өмчит аж ахуйт тооцоот үйлдвэрийн газар зэрэг байгууллагуудад санхүүгийн хяналт, мөн Монгол Улсын Сангийн яамны Улсын ахлах байцаагчийн 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 09/01-02 дугаар албан шаардлагын дагуу ажлын хэсэг байгуулан Ховд аймгийн үерийн хамгаалалтын далангийн шинэчлэл, засварын ажлын гүйцэтгэлийг хянах шалгалтын ажлууд шалгалт хийгдсэн.

Мөн энэ онд Дотоод аудитын хорооны хурлаар Санхүүгийн хяналт аудитын албаны 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, актын төлбөртэй холбоотой нас барсан иргэн, татан буугдсан байгууллагуудтай холбоотой зарим төлбөрийг хасах зэрэг шийдвэрүүдийг гаргуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХОЁР. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ШАЛГАЛТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫН ТАЛААР.

Санхүүгийн хяналт шалгалтаар нийтдээ 89 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 199 ширхэг улсын ахлах байцаагчийн актаар Орон нутгийн төсвийн орлогод 249.7 сая төгрөг, тухайн байгууллагын төсөвт орох, нөхөн олгох, сум хөгжүүлэх сангийн төсөвт оруулахаар 18.2 сая төгрөгийн, нийт 268.5 сая төгрөгийн акт тогтоож, улсын байцаагчийн 1 албан шаардлагаар 2.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар тус тус шийдвэрлэж ажилласан байна.

Тайлант хугацааны актын төлбөрийг 12 дугаар сарын байдлаар тухайн онд орон нутгийн төсөвт оруулахаар тогтоосон актын 41.6% буюу орон нутгийн төсвийн орлогын 110.6 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 42.2 сая төгрөг, нийт 152.9 сая төгрөгийг төсвийн орлогод 100160051411 тоот дансанд, тухайн сум орон нутгийн төсөв, данс бүртгэлд тусгахаар тогтоосон актаас 262.2 сая төгрөгийг барагдуулсан байна.

Өмнөх оны актын төлбөрийн үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 450.9 сая төгрөг байсан бол 2022 оны 12 сарын байдлаар өмнөх оны актын төлбөр

147.5 сая төгрөг болж, 67.3%-иар, 2022 онд тогтоосон актын төлбөрийн үлдэгдэл 156.7 сая төгрөг болж, 41%-иар барагдсан байна. 2022 оны 12 дугаар сарын байдлаар актын үлдэгдэл 304.2 сая төгрөг байгаагаас 260.9 сая төгрөг орон нутгийн төсөвт орохоор, 43.3 сая төгрөг тухайн байгууллагын болон ажилтанд буцаан олгох, данс бүртгэлд тусгах актын үлдэгдэлтэй байна.

Хугацаа хэтэрсэн, актын төлбөрөө төлөөгүй 10 хүнтэй холбоотой 7 актын нийт 6.1 сая төгрөгийн актыг барагдуулахаар шүүхэд шилжүүлсэн боловч нэхэмжлэлээс татгалзаад байна.

Тайлант хугацаанд 268.5 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрсэнийг зөрчлийн төрлөөр ангилан үзвэл:

1. Албан татвар төлбөр хураамж 0.71 хувь буюу 1.91 сая төгрөг
2. Төрийн өмч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй 3.5 хувь буюу 9.3 сая төгрөг
3. Зориулалт бусаар зарцуулсан 6.8 хувь буюу 18.3 сая төгрөг
4. Хандивлаж ивээн тэтгэсэн, их хэмжээгээр олгосон шагнал бэлэг дурсгалд 1.9 хувь буюу 5.2 сая төгрөг
5. Үндсэн баримтгүй зарцуулсан болон данс бүртгэлд тусгаагүй 13.9 хувь буюу 37.4 сая төгрөг
6. Өр авлага үндэслэлгүйгээр хаасан 0.2 хувь буюу 0.8 сая төгрөг
7. Дутуу болон илүү олгогдсон цалин хөлс, нөхөн олговор 46.1 хувь буюу 123.9 сая төгрөг
8. Ашиглаж дутагдуулсан хөрөнгө 0.6 хувь буюу 1.6 сая
9. Бусад 23.04 хувь буюу 61.8 сая төгрөг байна.
10. ЭМД, НДШ хураамж 2.3 хувь буюу 6.2 сая
11. Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр ой баяр тэмдэглэх, хандив, шагнал, бэлэг дурсгалд олгох 0.92 хувь буюу 2.4 сая төгрөг байна.

Үүнээс харахад нийт төлбөрийн дийлэнхийг үндсэн баримтгүй зарцуулсан, данс бүртгэлд тусгаагүй, дутуу болон илүү олгогдсон цалин хөлс, нөхөн олговор, бусад зэрэг зөрчил 13.9- 46.1 хувийг эзэлж байна.

Төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн нийтлэг зөрчил.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхжуулах сургалтын байр, хоолны төлбөр тэмцээний шагнал, сумын Иргэдийн Хурлын Төлөөлөгч, багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга, багийн Засаг дарга нарт шатахуун олгосон, няравын хувийн харилцах дансанд мөнгө шилжүүлсэн боловч тооцоо бодоогүй, өвс тэжээлийн тооцоо бодоогүй, өвс тэжээлийн үнийг авахаар байгаа боловч өвсний тооцоо бодоогүй, авахаар авлага дансанд тусгаагүй,

суудлын автомашинд дугуй, аккумулятор, бусад сэлбэг худалдан авахдаа ажилласан хугацааг тооцоогүй, жолоочийн хувийн харилцах дансанд зарим тохиолдолд сэлбэгийн үнийг шилжүүлж өгсөн, Монгол улсын Засгийн газрын тогтоол зөрчиж цайллага, хүлээн авалтад төсвийн хөрөнгө зарцуулсан, Зарим нэр бүхий ажилтанд амралт цалинг давхардуулан олгосон, тушаал шийдвэргүйгээр ур чадвар, үр дүнгийн нэмэгдэл олгосон, цалин хөлсийг буруу тооцож олгосон, төсвийн тухай хууль зөрчиж төсвийн байгууллагаас хандив тусламж олгосон, замын хуудас бодоогүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль зөрчиж тэмцээн уралдааны шагнал, орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зардалд зарцуулсан, хүүхдийн хоол хүнсний зардлыг зориулалт бусаар зарцуулсан, Төрийн аудитын байгууллагаас тогтоосон акт төлбөрийг төсвөөс төлсөн, жолоочийн тооцоо бодоогүй, замын хуудсанд үндэслэлгүйгээр километрийг илүү бичсэн, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, шууд болон шууд бус орлогоос татвар суутгаагүй, эмийн тайлан гаргаагүй, хоолны зардлын нормативээс хэтрүүлэн зарцуулсан, хөрөнгө дутагдуулсан, бараа материалыг хүлээлгэн өгөөгүй, төсөв хохироосон, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт дүрэм журмуудыг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалт



Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг улирал бүр гарган аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд 12 өргөдөл, 193 албан бичиг ирсэнийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлж ажилласан ба 188 бичгийг дээд шатны байгууллага, хууль шүүхийн байгууллагад явуулж ажилласан байна.

ГУРАВ. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.

Дорнод аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргаас Дотоод аудитын сургалт авч албан хаагчид бүрэн хамрагдсан. 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хооронд Төрийн албаны зөвлөл, “Мерит төсөл”-өөс зохион байгуулсан төрийн албан хаагчдыг чадавхжуулах онлайн сургалтанд алба хаагчдыг бүрэн хамрагдсан. Мөн тайлант жилд аймгаас зохион байгуулагдаж буй сургалтуудад бүрэн хамрагдлаа.

Тус албаны www.sankhuu.kho.gov.mn мэдээллийн сайтаараа дамжуулан



байгууллагын үйл ажиллагаа, шалгалтын дүн мэдээ, тушаал шийдвэр, сургалтын чиглэлээр нээлттэй мэдээллэж, сурталчилж байна.

Мөн албаны мэдээ, мэдээлэл, төрийн байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнуудад зориулсан хууль, тогтоомжуудыг www.facebook.com/sxaa.hovd сошиал хуудсаар дамжуулан хүргэж байна.

ДӨРӨВ. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.

Байгууллагын урсгал санхүүжилтанд 164.3 сая төгрөг төсөвлөж, гүйцэтгэлээр 164.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

№	Төсвийн байгууллага/ эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Хэмнэлт/ хэтрэлт
		Жилээр	Тайлант үе /өссөн дүнгээр/		
1	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	164285.7	164285.7	164285.7	0
2	УРСГАЛ ЗАРДАЛ	162619.0	162619.0	162619.0	0
3	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	148625.0	143285,4	152163,4	0
4	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	132342.9	132342.9	132342.9	0
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16542.8	16542.8	16542.8	0
6	Хангамж, бараа материалын зардал	6557.9	6557.9	6557.9	0
7	Эд хогшил, урсгал засварын зардал	596.7	596.7	596.7	0
8	Томилолт, зочны зардал	4544.2	4544.2	4544.2	0
9	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1551.2	1551.2	1551.2	0

10	Бараа үйлчилгээний бусад зардал	483.3	483.3	483.3	0
11	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	1666.7	1666.7	1666.7	0
12	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	164285.7	164285.7	164285.7	0
13	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164285.7	164285.7	164285.7	0

2022 оны байдлаар байдлаар тус албаны цалин хөлсний зардал 132342.9 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд сард дунджаар 16542.8 мянган төгрөгийн цалин хөлсний зардал гаргахаар батлагдсан бөгөөд манай албаны 11 байцаагчийн хууль тогтоомжийн дагуу олгох цалин хөлс нь сард дунджаар 10958.9 мянган төгрөг байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны Улсын байцаагч, албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4.улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.”, 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.” гэж заасны дагуу үр дүнгийн мөнгөн урамшууллыг гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө дүгнүүлж авах төсвийн ямар ч боломжгүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хуулийн хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлж ажиллаж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээллийн самбараар болон шилэн дансны www.shilendans.gov.mn сайтад бүрэн байршуулж ажиллалаа.

ТАВ. БУСАД

Тэрбум мод-Үндэсний хөдөлгөөний талаар: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд “Санхүүгийн хяналт, дотоод аудит”-ын олон нэгдэж мод тарьсан.



Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын санаачилгаар “Хоггүй Ховд” бүх нийтийн их цэвэрлэгээнд хамт олноороо оролцов.



ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Үйл ажиллагааны талаар: Ховд аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь санхүүгийн хяналт, дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гарган эрсдэлийн удирдлагаар ханган ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсангүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт ажлууд бүрэн хийгдэж байна.

Албан хаагчид төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн дүрэм, дотоод аудитын ёс зүйн дүрмийг чанд мөрдөн сахилгын зөрчилгүй ажилласан.

Байгууллагын ажилчдыг сургалт семинарт хамруулах, мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дотоод журамд тусган хэрэгжүүлэн ажилласан.

Санхүүгийн хяналт шалгалтаар: Нягтлан бодох бүртгэлийн программ хангамж, техник хэрэгслээр бүртгэлийн ажлыг зохион байгуулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд төрийн сан урьдчилсан хяналт тавьж ажилладаг болсноор төсвийн

хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сайжирсан. Гэвч урьд өмнө нгарч байсан зөрчил давтагдах, төлбөр зөрчлийг цаг хугацаанд нь барагдуулах талаар төсвийн менежер, санхүүгийн ажилтан нар хангалтгүй ажиллаж байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар аймгийн Засаг даргаар ахлуулсан дотоод аудитын хороонд танилцуулж, цаашид хяналт шалгалтын зөрчлийг бууруулах талаар холбогдох арга хэмжээ, шийдвэрүүдийг гаргуулж ажилласан.

ХЯНАСАН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА *[Signature]* Г.ӨӨДЭЙ
ТАЙЛАН БИЧСЭН
ДОТООД АУДИТОР *[Signature]* Г.АРИУНЧИМЭГ
1632020010